ГОЛОМТ БАНК
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*




Гарын авлага >>>>>

# ИНТЕРНЭТ БАНК

## ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛ АВАХ

ГОЛОМТ БАНК
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

# Тэтгэврийн зээлийн хүсэлт илгээх







АЛХАМ 1
Та Egolomt.mn вэбсайт руу нэвтрэн зүүн хэсэгт байрлах "Зээл - Тэтгэврийн зээл" цэс рүү орно.

АЛХАМ 2
Зээлийн ерөнхий нөхцөл, хүү шимтгэлтэй танилцаж "Үргэлжлүүлэх" товчийг дарна.

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

# Тэтгэврийн зээлийн хүсэлт илгээх







### АЛХАМ 3

Та өөрийн хувийн мэдээллийг шалган "Үргэлжлүүлэх" товчийг дарна. *Хэрэв таны мэдээлэл зөрүүтэй бол "Засах" товчийг дарж мэдээллээ шинэчлэх боломжтой.

### АЛХАМ 4

Зээлийн хугацаа, зээлийн дүн болон бусад мэдээллүүдийг бөглөж, Зээлийн мэдээлэл татах хэсгийг идэвхжүүлэн "Үргэлжлүүлэх" товчийг дарна.

ГОЛОМТ БАНК
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

# Тэтгэврийн зээлийн хүсэлт илгээх







АЛХАМ 5

Тэтгэврийн зээлийн мэдээллийг шалган "Үргэлжлүүлэх" товчийг дарна.

АЛХАМ 6

Үйлчилгээний гэрээ / нөхцөлтэй танилцан "Зөвшөөрсөн" сонголтыг дарж, батлах нууц үгээ оруулан "Баталгаажуулах" товчийг дарснаар зээлийн хүсэлт илгээгдэх болно.

# Тэтгэврийн зээлийн хүсэлт илгээх




АЛХАМ 7

Таны зээлийн хүсэлт амжилттай илгээгдлээ. Таны бүртгэлтэй гар утасны дугаарт зээлийн хариу илгээгдэх болно.

ГОЛОМТ БАНК
*Сайн сайхныг санхүүжүүлнэ*

# Тэтгэврийн зээлийн хүсэлт баталгаажуулах







АЛХАМ 9
Зээлийн төлөв хэсэгт зээлийн шийдвэр харагдах бөгөөд "Шийдвэр баталгаажуулах" товчийг дарна.

АЛХАМ 8
Та egolomt.mn вэбсайт руу нэвтрэн орж зүүн хэсэгт байрлах "Зээл - Тэтгэврийн зээл" цэс рүү орж "Зээлийн төлөв" товчийг дарна.

# Тэтгэврийн зээлийн хүсэлт баталгаажуулах




АЛХАМ 10

Зээлийн нөхцөлтэй танилцан дүн болон олголт хийх дансыг сонгон "Баталгаажуулах" товчийг дарна.

# Тэтгэврийн зээлийн хүсэлт баталгаажуулах


11

1.2 Зээлдэгч нь энэхүү гэрээг цахим хэлбэрээр байгуулах ба авч ашиглаж буй зээлийн төлбөрөө эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөхөө баталгаажуулж байна.

ХОЁР. ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

2.1 Зээлдэгч нь Банктай байгуулсан Дижитал зээлийн эрх нээх гэрээ, Дижитал зээлийн эрхийн нөхцөлийн дагуу дараах нөхцөл бүхий зээлийг авахаар хүсэлт гаргасныг Банк зөвшөөрсөн болно. Үүнд:
- 2.1.1 Зээлийн хэмжээ: 20,000,000.00 төгрөг
- 2.1.2 Зээлийн хүү /Жилийн/: 15.6 %
- 2.1.3 Зээлийн хугацаа: 18 сар
- 2.1.4 Зээлдэгчийн харилцах данс: [illegible]
- 2.1.5 Зээлийн данс: Зээлийн дансны дугаар нь гэрээний хавсралтад заасанаар тодорхойлогдоно. Хавсралтыг таны Банканд бүртгэлтэй и-мэйл хаягт илгээнэ.
- 2.1.6 Хяналт, эрсдэл менежментийн шимтгэл: 0%
- 2.1.7 Сар болгоны төлөлт хийх өдөр: Сард 1 удаа 1-ний өдөр
- 2.1.8 Эргэн төлөлтийн хуваарь: Энэхүү гэрээний хавсралтаар тодорхойлогдоно.

2.2 Талууд гэрээний хавсралт болох Зээлийн эргэн төлөлтийн хуваарийг энэхүү гэрээний хамт Зээлдэгчийн -мэйл хаягаар хүргүүлэх ба харилцагч эргэн төлөлтийн хуваарьтай танилцаж хуваарийн дагуу зээл төлөх үүрэгтэй байна.

2.3 Зээлдэгч нь зээл авсан өдрөөс эхлэн түүнийг бүрэн төлж дуусах хүртэл хугацаанд төлөгдөөгүй байгаа зээлийн үлдэгдэлд зээлийн гэрээний хугацаа дууссанаас үл хамааран сар бүр энэхүү гэрээнд заасан зээл, зээлийн хүүг төлнө.

2.4 Зээлийн нэг өдрийн хүүг тооцохдоо жилийн хүүг 365 хоногт хувааж, нийт хүүг тооцохдоо ашигласан хоногоор үржүүлнэ.

2.5 Зээлдэгч нь гэрээний хавсралт болох эргэн төлөлтийн хуваарьт хугацааг чанд баримтлах нь Дижитал зээлийн эрх нээх гэрээний нэн чухал нөхцөл бөгөөд түүнийг удаа дараа зөрчвөл Дижитал зээлийн эрх нээх гэрээг ноцтой зөрчсөн гэж үзнэ.

2.6 Зээлдэгч эргэн төлөлтийн хуваарьт заасан өдрөөс урьдчилан үндсэн зээлийн илүү төлөлт хийсэн тохиолдолд хуваарьт төлбөрөөс чөлөөлөх нөхцөл болохгүй бөгөөд зээлийн хүүгийн төлөлт буурах болон төлөгдөж дуусах хугацаа богиносох нөхцөл болно.

2.7 Гэрээний эргэн төлөлтийн хуваарьт заасан үндсэн зээл болон хүүгийн дүн нь зээлдэгчийн эргэн төлөлтөөс хамаарч өөрчлөгдөж байх бөгөөд сар бүр төлөх тэнцүү дүн нь зээлийн гэрээний хугацаанд тогтмол байна.

2.8 Зээлдэгч хуваарьт төлбөрийн дагуу зээлээ хугацаандаа төлөөгүй тохиолдолд нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ дараагийн хуваарьт төлөлтөд нэмж тооцогдоно

2.9 Зээлдэгч эргэн төлөх хуваарьт хугацаанд зээлийн төлбөрийг төлж барагдуулаагүй бол зээл төлөгдөх хуваарьт өдрийн дараах өдрөөс эхлэн зээлийн хүүг үргэлжлүүлэн төлөхөөс гадна үндсэн хүүгийн 20%-тай тэнцэх хэмжээний нэмэгдүүлсэн хүүг зээлийн эргэн төлөлтийг хуваарьт хугацаанд нийцүүлэх хүртэл хугацаанд төлөхөөр Талууд харилцан тохиролцов.

2.10 Зээлдэгч гэрээнд заасан хугацаанд зээл, хүү, нэмэгдүүлсэн хүүний төлбөрөө төлөөгүй тохиолдолд зээлдэгчийн аливаа данснаас банк суутган төлүүлэх эрхтэй байна.

2.11 Зээлдэгч дижитал зээлээр авсан бараа бүтээгдэхүүнээ буцаах тохиолдолд банк зээлийг буцаан төлүүлэх эрхтэй байх ба төлсөн байгаа зээлийн хүү, шимтгэлийг буцаахгүй болно.

Дээрх нөхцөлийг зөвшөөрөн цахим хэлбэрээр нууц үг, нууц код ашиглан зөвшөөрснөөр гэрээнд гарын үсэг зурсантай адилтгагдахыг талууд харилцан зөвшөөрөв.

☑ Үйлчилгээний гэрээ / нөхцөлтэй танилцаж зөвшөөрсөн болно

Батлах нууц үг

Батлах нууц үг

Мартсан ?

Баталгаажуулах




АЛХАМ 11

Тэтгэврийн зээлийн гэрээтэй танилцан Батлах нууц үгээ оруулан "Баталгаажуулах" товчийг дарснаар таны зээл олгогдох болно.

# Танд амжилт хүсье.